



ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН
ДАРГЫН ТУШААЛ

2019 оны 04 сарын 05 өдөр

Дугаар 1/16

Арвайхээр

Дотоод журмын хавсралтад нэмэлт
оруулах тухай

Жендэрийн эрх тэгш байдлыг хангах тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.3.9, 11.4.1 дэх заалт, аймгийн Засаг даргын Тамгын газрын даргын 2018 оны а/43 дугаар тушаалын хавсралтаар батлагдсан “Өвөрхангай аймгийн Засаг даргын Тамгын газрын хөдөлмөрийн дотоод журам”-ын 11.1.3 дахь заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Аймгийн Засаг даргын Тамгын газрын даргын 2018 оны а/43 дугаар тушаалын хавсралтаар батлагдсан “Өвөрхангай аймгийн Засаг даргын Тамгын газрын хөдөлмөрийн дотоод журам”-д дор дурдсан агуулгатай 6.1.9, 6.1.10, 8.2.6 дахь заалтыг тус тус нэмсүгэй.

”6.1.9. Жирэмсэн болон амаржсны амралттай, хүүхэд асрах чөлөөтэй, эрүүл мэндийн улмаас 3 сараас 1 жил хүртэл хугацаагаар эмчлүүлсэн ажилтны мэргэшил, ур чадварыг дээшлүүлэх зорилгоор мэргэжил, хариуцсан ажлын чиг үүргийн хүрээнд тэднийг давтан сургалтад хамруулна”.

“6.1.10. Ажил олгогч ажлын байранд бэлгийн дарамт гарахаас урьдчилан сэргийлэх, бэлгийн дарамтаас ангид орчин бүрдүүлэх, ажилтныг жендэрийн ялгаварлан гадуурхалт, бэлгийн дарамтын талаар ойлголт, мэдээлэл авах, сургалтад хамруулж, бэлгийн дарамтад өртөж болзошгүй нөхцөл байдал үүсч буй тохиолдолд байгууллагын ёс зүйн хороонд ажилтан гомдол гаргах эрхтэй бөгөөд ёс зүйн хороо нь хувь хүний нууцлалыг хадгалж, холбогдох хууль тогтоомжийн дагуу шийдвэрлэнэ.

8.2.6. Ажлын байранд бэлгийн дарамтыг үг хэлээр, биеэр, өөр хэлбэрээр илэрхийлэх, сэтгэл санааны болон бусад байдлаар хохироохыг хориглоно.

2. Энэхүү дотоод журмын хавсралтад орсон нэмэлтийг 2019 оны 3 дугаар сарын 1-ний өдрөөс эхлэн мөрдсүгэй.

ДАРГА



Ц.ГАНБОЛД

012100057

D: My Doc. Tushaal. ZDTG